

## ТАНИЛЦУУЛГА

### 2023 ОНЫ ХАГАСЖИЛИЙН БАЙДЛААР ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ГАРГАСАН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ

2023.06.20

Хараат

Сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар болон төсвийн байгууллагуудад мэргэжилтнүүдэд хандан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэхдээ холбогдох албан тушаалтнууд “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол улсын хууль, Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 67-р тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон амаар, бичгээр, 75775959 утсаар ажлын цагаар хүлээн авч ажиллаж байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд ирүүлсэн ӨГСХ-ийг бүртгэлжүүлэн удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтанд өгч шийдвэрлүүлж, хариуг эзэнд нь утсаар болон албан бичгээр биечлэн уулзаж өгч байна.

2023 оны 2 дугаар улиралд иргэдээс 52 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирснийг хуулийн хугацаанд 76 хувийн биелэлттэй шийдвэрлэсэн байна. Хугацаа болоогүй 6 өргөдөл, гомдол, санал, хүсэлт шийдвэрлэх шатандаа явагдаж байна.

**Өргөдөл шийдвэрлэхэд зарцуулсан хөрөнгө:** Одоогоор зарцуулсан хөрөнгө мөнгө гараагүй болно.

**Шийдвэрлэхэд хүндрэлтэй өргөдөл хэдэн хувь байсан:** Шийдвэрлэхэд хүндрэлтэй өргөдөл байхгүй байна.

**Нийт өргөдлийн хэдэн хувийг эерэгээр шийдвэрлэсэн:** 76% эерэгээр шийдвэрлэсэн.

**Шийдвэрлэлтийн дундаж хоногийг тооцоолсон байдал:** 1 өргөдлийн шийдвэрлэлтийн дундаж хоног 7-5 хоногтой байна. Тухайн өргөдлийг шийдвэрлэхэд иргэдээс хөрөнгө, мөнгө хүссэн өргөдөл ирээгүй байна.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР